

4

COVID-19 ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ

Буруу зан үйл

Бүх хүүхдүүд муухай ааш гаргадаг. Тэд ядарсан, өлссөн, айсан эсвэл бие даан суралцах үедээ ийм ааш, авир гаргах нь хэвийн юм. Мөн тэд гэртээ байхаараа биднийг галзууруулах шахдаг.

Өөр тийш чиглүүлэхийг хичээ

Буруу үйлдэл гаргамагц нь хүүхдээ зөв зан үйл рүү чиглүүл

Эхлэхээс нь өмнө зогсоо! Тэд тайван бүс болж эхлэхэд, илүү сонирхолтой, хөгжилтэй зүйлсэд анхаарлыг нь хандуул: «Гарч алхацгаая!» гэх мэт



Завсарлага ав

Уурлаж хашгирмаар байна уу? Өөртөө 10 хором гарга. 5 удаа гүнзгий амьсгаа ав. Тэгээд тайвнаар хариулахыг хичээгээрэй.

Энэ аргыг олон эцэг эхүүд сайшаадаг шүү- маш ихээр сайшаадаг

Буруу зүйл хийснийх нь төлөө хариуцлага тооц.

Хүүхдүүд буруу зүйл хийснийхээ төлөө хариуцлага хүлээх хэрэгтэй. Ингэж байж л тэд сахилга баттай болно. Энэ нь зодож загнахаас илүү үр дүнтэй арга юм.

1-3-р хуудасны зөвлөмжийг дахин давтан хэрэгжүүл

Ганцаарчлан харилцах, сайн үйлдлийг нь магтах, өдөр тутмын тогтсон цагийн хуваарь тэдний зан аашинд эергээр нөлөөлдөг. Бага насны болон өсвөр насны хүүхдэдээ энгийн ажил хариуцуулж өг. Тэдний хийж чадах ажлыг даалгаарай. Тэгээд хийснийх нь дараа магтан урамшуул.

Хүүхдүүддээ хариуцлага хүлээлгэхээсээ өмнө таны зааврыг дагах сонголт өг.

Хүүхдүүддээ хариуцлага хүлээлгэхдээ ч тайван байхыг хичээ

Хариуцлага хүлээлгэсэн бол түүштай байгаарай. Жишээлбэл, өсвөр насны хүүхдээ долоо хоног утасгүй байлгахгаар шийтгэх нь хэцүү. Харин оронд нь нэг цаг утаснаас нь хол байлгавал илүү бодитой болно.

Хариуцлага хүлээлгэж дууссан бол хүүхдэдээ сайн зүйл хийх боломж олгон, магтан сайшаагаарай

